



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/312

Өмнөдэлгэр сум

**Газрын дуудлага худалдааны
комисс томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 09 дугаар сарын 02-ний өдрийн 74 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн 2025 оны 05 дугаар сарын 06-ний өдрийн 05 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн 2025 оны 08 дугаар сарын 13-ний өдрийн 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Өмнөдэлгэр суманд явуулах газар эзэмших дуудлага худалдааны комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Гантулга	Нягтлан бодогч
Дуудлага худалдааны хөтөч: Ё.Мөнх-Өлзий	Газрын даамал
Тэмдэглэл хөтлөгч: Д.Баярхүү	Татварын улсын байцаагч

2.Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, газар эзэмших эрх авсан иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг газрын даамал (Ё.Мөнх-Өлзий)-д даалгасугай.



Р.ЭНХТӨР